



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалтын
аргачлал батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын төсөв болон даатгалын сангийн санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтад хамрагдах тусламж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, сонгон шалгаруулалт явуулах хугацаа, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг нэгдүгээр, улс, бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, сонгон шалгаруулалтын урилгын загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтын тайлан, дүнг зохих журмын дагуу баталгаажуулан 2015 оны 5 дугаар сарын 10-ны дотор Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нар болон Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Сонгон шалгаруулах комиссын дүгнэлтийг үндэслэн, сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын талаар холбогдох шийдвэрийг гаргуулж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар (Р.Оюунханд)-т үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн

080454

санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журам батлах тухай” 418 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн)-т даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
04 дугаар сарын 07 ний өдрийн
131 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ
үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтад хамрагдах
тусламж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, сонгон шалгаруулалт
явуулах хугацаа, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ
үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэхүү
аргачлалын дагуу зохицуулна.

1.2 Улс, бүсийн хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө
оруулалттай эрүүл мэндийн байгууллагыг тус тушаалаар байгуулагдсан комисс,
аймаг, нийслэлийн хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг аймаг,
нийслэлийн Засаг даргын томилсон комисс тус тус сонгон шалгаруулах ажлыг
зохион байгуулна.

1.3 “Улсын төсөв болон даатгалын сангийн санхүүжилтээр тусламж
үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журам”-ын 1.5, 2.2-т
заасныг үндэслэн сонгон шалгаруулалтын комиссын ажлыг аймаг, нийслэлийн
Эрүүл мэндийн газар удирдан, бүрэлдэхүүнд нийгмийн даатгал, мэргэжлийн
хяналтын, хувийн хэвшлийн, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг
оролцуулна.

1.4 Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах
тусламж, үйлчилгээний төрөл нь “Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр-хувийн
хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ын үндсэн зарчимд нийцсэн
байх ба орон нутгийн болон төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амд
үзүүлж буй тусламж, үйлчилгээний хүчин чадлаас давсан, ачаалал, хүлээгдэл
ихтэй, цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээтэй тусламж, үйлчилгээ
байна.

1.5 Сонгон шалгаруулалтад хамрагдах эрүүл мэндийн байгууллагын
тусламж, үйлчилгээний төрлийг тухайн байгууллагын тусгай зөвшөөрөлд заасан
чиглэлийн дагуу тогтооно.

1.6 Комисс нь сонгон шалгаруулалт явуулах тухай зар, урилгыг орон нутгийн
болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сонгон шалгаруулалтаас 30
хоногийн өмнө зарлаж мэдээлсэн байна.


1.7 Комисс нь сонгон шалгаруулалтыг 2015 оны 05 дугаар сарын 05-ны дотор багтаан зохион байгуулж, зохих журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан сонгон шалгаруулалтын тайлан, дүнг Эрүүл мэнд, спортын яаманд тогтоосон хугацаанд ирүүлнэ.

Хоёр. Тусламж, үйлчилгээний төрөл

Д/д	Аймаг, нийслэл	Тусламж, үйлчилгээний багц ба төрөл					
		Хэвтүүлэн эмчлэх				Амбулаторийн үзлэг, эмчилгээ	Оношилгоо, шинжилгээ
		Үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	Уламжлалт анагаах тусламж, үйлчилгээ	Сэргээн засахын тусламж, үйлчилгээ		
1	Архангай	Дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хүүхэд, мэс засал	✓	✓	✓	--	--
2	Баян-Өлгий	Дотор, мэдрэл, мэс засал	✓	✓	✓	--	--
3	Баянхонгор	Дотор, мэдрэл, арьс, нүд, эмэгтэйчүүд	✓	✓	✓	--	--
4	Булган	Дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад	✓	✓	✓	--	--
5	Говь-Алтай	Дотор, мэс засал	✓	✓	✓	--	--
6	Говьсүмбэр	Дотор, хүүхэд, чих хамар хоолой	✓	✓	✓	--	--
7	Дархан-Уул	Дотор, хүүхэд, эмэгтэйчүүд, нүд, чих хамар хоолой, арьс харшил, мэс засал	✓	✓	✓	--	--
8	Дорноговь	Хүүхэд, мэдрэл	✓	✓	✓	--	--
9	Дорнод	Дотор, мэдрэл	✓	✓	✓	--	--
10	Дундговь	Дотор, мэдрэл, хүүхэд	✓	✓	✓	--	--
11	Завхан	Дотор, мэдрэл	✓	✓	✓	--	--
12	Орхон	Дотор, эмэгтэйчүүд, чих хамар хоолой	✓	✓	✓	--	--
13	Өвөрхангай	Дотор, хүүхэд,	✓	✓	✓	--	--

		эмэгтэйчүүд					
14	Өмнөговь	Дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хүүхэд, мэс засал	✓	✓	✓	--	--
15	Сүхбаатар	Дотор, хүүхэд, мэдрэл	✓	✓	✓	--	--
16	Сэлэнгэ	Дотор, эмэгтэйчүүд, хүүхэд, чих хамар хоолой, мэдрэл	✓	✓	✓	--	--
17	Төв	Дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хүүхэд	✓	✓	✓	--	--
18	Увс	Дотор, мэс засал, эмэгтэйчүүд, мэдрэл, нүд	✓	✓	✓	--	--
19	Ховд	Дотор, мэдрэл, мэс засал, арьс харшил,	✓	✓	✓	--	--
20	Хөвсгөл	Дотор, эмэгтэйчүүд, мэдрэл, мэс засал	✓	✓	✓	--	--
21	Хэнтий	Дотор, хүүхэд	✓	✓	✓	--	--
22	Улс, бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагууд	Дотор, хүүхэд, эмэгтэйчүүд, гэмтэл, мэс засал, нүд, чих хамар хоолой, мэдрэл, сэтгэц, арьс	✓	✓	✓	--	--
23	Нийслэлийн хэмжээнийн хүн амд тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	Дотор, эмэгтэйчүүд, мэс засал, нүд, хүүхэд, чих хамар хоолой, гэмтэл, сэтгэц, мэдрэл	✓	✓	✓	--	--
24	Гэрээгээр төрийн үйлчилгээг	Мэс засал, гэмтэл	--	--	--	Мэс засал, гэмтэ	Мэс засал, гэмтэл

дангаар гүйцэтгэх эрүүл мэндийн байгууллагууд (нийслэлийн хүн ам)						л			
---	--	--	--	--	--	---	--	--	--



Гурав. Сонгон шалгаруулалтын хамрах хүрээ

3.1 Сонгон шалгаруулалтад аймаг, нийслэлийн болон улс, бүсийн хэмжээний үйлчилгээтэй, гадаадын хөрөнгө оруулалттай, магадлан итгэмжлэгдсэн дор дурдсан хувийн өмчит эрүүл мэндийн байгууллагууд хамрагдана:

- 3.1.1 төрийн чиг үүргийг дангаар үзүүлэх мэс заслын болон гэмтлийн тусламж, үйлчилгээ эрхэлдэг хувийн өмчит эмнэлэг;
- 3.1.2 эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний багцын үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн бүх төрлийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний эмнэлэг;
- 3.1.3 эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний багцын эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэвтүүлэн эмчлэх сувилал, хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт

4.1 Сонгон шалгаруулалтад оролцох хувийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тавих шалгуур үзүүлэлт нь ерөнхий болон тусгай гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

4.2 Ерөнхий шалгуур үзүүлэлт нь тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хүчин чадлыг илтгэнэ.

4.3 Тусгай шалгуур үзүүлэлт нь тухайн эрүүл мэндийн байгууллагаас хүн амд үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанарыг илтгэнэ.

4.4 Гэрээгээр төрийн үйлчилгээг дангаар гүйцэтгэх эрүүл мэндийн байгууллагад тавих сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт нь тушаалын 3.1.2, 3.1.3-т заасан эрүүл мэндийн байгууллагын шалгуур үзүүлэлтээс тусдаа байна.

4.5 Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах хэвтүүлэн эмчлэх, уламжлалт анагаах, хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх, сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг, сувилалын шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлтүүд		Мэдээллийн эх үүсвэр	Үнэлгээ
Нэг. Ерөнхий шалгуур үзүүлэлт			
1	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх	Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн	Хангасан /хангаагүй

		гэрчилгээ	
2	Хүчин төгөлдөр магадлан итгэмжлэлтэй байх	Магадлан итгэмжлэлийн батламж	Хангасан /хангаагүй
3	Эмнэлгийн бодит орны тоог бүрэн байршуулах хангалттай эрүүл ахуйн нөхцөл бүрдсэн байх	Батлагдсан орны тоог үйл ажиллагааны чиглэлээр хуваарилсан байгууллагын даргын шийдвэр; Байгууллагын дотоод зохион байгуулалтын бүдүүвч зураг	Хангасан /хангаагүй
4	Эмнэлгийн мэргэжилтэн (эмч, сувилагч)-ий 90-ээс доошгүй хувь нь үндсэн ажилтан байх	Байгууллагын бүтэц, орон тоог баталсан шийдвэр; Нийгмийн даатгалын НД7, НД8 тайлан	Хангасан /хангаагүй
5	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар /ЭТҮХХ/-ын тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, мэдээллэх тогтолцоо бүрдсэн байх	ЭТҮХХ-ын тохиолдлыг илрүүлэх, бүртгэх тухай байгууллагын даргын шийдвэр; ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны мэдээ	Хангасан /хангаагүй
6	Дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлсэн байх	Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн тухай байгууллагын даргын тушаал; Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Хангасан /хангаагүй
7	Байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн байх	Стратеги төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан /өмнөх жилийн тайлан/	Хангасан /хангаагүй
8	Эрүүл мэндийн өдөр тутмын үйл ажиллагаа, статистик мэдээ, тайланг тогтоосон хугацаанд мэдээлсэн байх	Эмнэлэг, сувилалын статистик мэдээ, тайлангийн хугацаа, мэдээний бодитой байдлын талаарх ЭМХТ, аймаг, нийслэлийн ЭМГ-ын дүн	Хангасан /хангаагүй
9	Өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал	Байгууллагын даргын тушаалаар батлагдсан “Өвчтөн шилжүүлэх журам”; Лавлагаа төвтэй байгуулсан гэрээний хувь	Хангасан /хангаагүй

Хоёр. Тусгай шалгуур үзүүлэлт

1	Магадлан итгэмжлэлийн шалгуурын биелэлтийн хувь	90-100%	Магадлан итгэмжлэл олгосон шийдвэр	2
		85-89 %		1
		85 %-аас доош		0
2	Тусламж, үйлчилгээг үзүүлэх хүний нөөцийн хангалт, мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний хувь	90-100%	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх; Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	2
		86-89 %		1
		85%-аас доош		0
3	Эмч, сувилагчийн зохистой харьцаа	1:2-оос доошгүй	Байгууллагын эрүүл мэндийн ажилтны бүтэц, орон тоо	2

	хангалттай байх	1:1.5-аас доошгүй	баталсан шийдвэр;	1
		1:1.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн НД7, НД8 тайлан	0
4	Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтанд хамруулсан байдал	90-100%	Сургалтын төлөвлөгөө, тайлан	2
		80-89%		1
		79-с доош %		0
5	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцтэй байх	90-100%	Тусламж, үйлчилгээний багц бүрийн бүтэц, үйл ажилагааны стандартад заасан • зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт • Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт • Зайлшгүй шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт	2
		80-89%		1
		79-с доош %		0
6	Орны фонд ашиглалт	91-100	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт (сүүлийн 3 жилийн байдлаар); Эрүүл мэндийн статистик мэдээ	2
		81-90		1
		80-аас доош		0
7	Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээрх нэвтрүүлсэн сайн туршлагын тоо	2-3	Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайлан (тусламж, үйлчилгээний чанарыг хөгжүүлэх хөтөлбөр)	2
		1-2		1
		0		0
8	Эмнэлгийн алдаа, түгээмэл үйлдлийн алдааг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний тоо, төрөл	3 ба түүнээс дээш	Чанарын албаны болон дотоод хяналтын тайлан, арга хэмжээний баримт материал; Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан	2
		3 хүртэл		1
		Арга хэмжээ аваагүй		0
9	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь /Сүүлийн 12 сараар/	80-аас дээш%	Тухайн байгууллагын өнгөрсөн хугацаанд авсан сэтгэл ханамжийн судалгааны дундаж	2
		75-80%		1
		75-аас доош%		0
10	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар ирүүлсэн санал, хүсэлтийг хэрэгжүүлсэн хувь	80-аас дээш%	Тухайн байгууллагын өнгөрсөн хугацаанд үйлчлүүлэгдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дагуу хийсэн ажлын тайлан	2
		75-80%		1
		75-аас доош%		0
	Хөгжлийн бэрхшээлтэй	80-100%	Хөгжлийн бэрхшээлтэй	2

11	үйлчлүүлэгчдэд зориулсан шаардлага хангасан дэд бүтэцийн хангасан байдал	60-79%	үйлчлүүлэгчдэд зориулсан дэд бүтцийг бүрдүүлсэн тайлан	1
		60%-с доош		0

4.6 Гэрээгээр мэс заслын болон гэмтлийн тусламж, үйлчилгээг дангаар гүйцэтгэх эрүүл мэндийн байгууллагын шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлтүүд		Мэдээллийн эх үүсвэр	Үнэлгээ
Нэг. Ерөнхий шалгуур үзүүлэлт			
1	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх	Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Хангасан /хангаагүй
2	Хүчин төгөлдөр магадлан итгэмжлэлтэй байх	Магадлан итгэмжлэлийн батламж	Хангасан /хангаагүй
3	Амбулаторийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх нөхцөл бүрдсэн байх	Эмнэлгийн батлагдсан бүтэц Эрүүл зүйн шинжилгээний дүгнэлт	Хангасан /хангаагүй
4	Эрчимт эмчилгээний бэлэн байдлыг хангасан байдал	Эрчимт эмчилгээний нэгжийн бүтэц, хүний нөөцийг баталгаажуулсан шийдвэр Байгууллагын дотоод зохион байгуулалтыг харуулсан бүдүүвч зураг	Хангасан /хангаагүй
5	Эмнэлгийн бодит орны тоог бүрэн байршуулах хангалттай нөхцөл бүрдсэн байх	Батлагдсан орны тоо, Байгууллагын дотоод зохион байгуулалтыг харуулсан бүдүүвч зураг	Хангасан /хангаагүй
6	Эмнэлгийн мэргэжилтэн (эмч, сувилагч)-ий 90-ээс доошгүй хувь нь үндсэн ажилтан байх	Байгууллагын даргын тушаал, хөдөлмөрийн гэрээ, нийгмийн даатгалын шимтгэлийн НД 7, 8 тайлан	Хангасан /хангаагүй
7	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар /ЭТҮХХ/-ын тохиолдлыг илрүүлэх, бүртгэх тогтолцоо бүрдсэн байдал	ЭТҮХХ-ын тохиолдлыг илрүүлэх бүртгэл, мэдээлэл Орон тооны эрүүл ахуйч, халдвар судлаач ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны мэдээ	Хангасан /хангаагүй
8	Дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлсэн байх	Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн тухай байгууллагын даргын тушаал, авсан арга хэмжээний тайлан	Хангасан /хангаагүй
9	Байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн байх	Стратеги төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан /өмнөх жилийн тайлан/	Хангасан /хангаагүй
10	Эрүүл мэндийн өдөр тутмын үйл ажиллагаа, статистик мэдээ, тайланг тогтоосон хугацаанд мэдээлсэн байх	Эмнэлэг, сувилалын стантистик мэдээ, тайлангийн хугацаа, мэдээний бодитой байдлын талаарх ЭМХТ, аймаг,	Хангасан /хангаагүй


			нийслэлийн ЭМГ-ын дүн	
11	Өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал		Байгууллагын даргын тушаалаар батлагдсан "Өвчтөн шилжүүлэх журам" Лавлагаа төвтэй байгуулсан гэрээний хувь	Хангасан /хангаагүй
Хоёр. Тусгай шалгуур үзүүлэлт				
1	Магадлан итгэмжлэлийн шалгуурын биелэлтийн хувь	90-100%	Магадлан итгэмжлэл олгосон шийдвэр	2
		85-89 %		1
		85 %-аас доош		0
2	Тусламж, үйлчилгээг үзүүлэх хүний нөөцийн хангалт, мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний хувь	90-100%	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл /нотариатаар баталгаажсан хуулбар/	2
		86-90 %		1
		85%-аас доош		0
3	Эмч, сувилагчийн зохистой харьцаа хангалттай байх	1:2-оос доошгүй	Байгууллагын эрүүл мэндийн ажилтны бүтэц, орон тоо баталсан шийдвэр, Нийгмийн даатгалын шимтгэлийн НД7, НД8 тайлан	2
		1:1.5-аас доошгүй		1
		1:1.4		0
4	Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтанд хамруулсан байдал	90-100%	Сургалтын төлөвлөгөө, төгсөлтийн дараах давтан сургалтын тайлан	2
		80-89%		1
		79-с доош %		0
5	Дурангийн мэс заслын болон өндөр өртөгтэй оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчдийн эзлэх хувь	30%-аас дээш	Тусламж, үйлчилгээний бүртгэл, мэдээ	2
		10-29%		1
		10-аас доош		0
6	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн бүрдэл	90-100%	Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт Зайлшгүй шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт	2
		80-89%		1
		79-с доош %		0
7	Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээрх нэвтрүүлсэн сайн туршлагын тоо	2-3	Тусламж, үйлчилгээний чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний тайлан; Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан	2
		1-2		1
		0		0
8	Эмнэлгийн тоног	90-100%	Зайлшгүй шаардлагатай тоног	2

	төхөөрөмжийн шинэчлэл, ашиглалтын байдал	80-89%	төхөөрөмжийн жагсаалт Худалдан авалт, засвар үйлчилгээний гэрээ	1
		79-с доош %		0
9	Лабораторийн дотоод хяналтын гүйцэтгэл, гадаад хяналтын хамрагдалтын байдал	96-100%	Лабораторийн дотоод хяналтын тайлан үзүүлэлт	2
		90-95 %		1
		85-89 %	Гадаад хяналтын тайлан	0
10	Эмнэлгийн алдаа, түгээмэл үйлдлийн алдааг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний тоо, төрөл	3 ба түүнээс дээш	Чанарын албаны болон дотоод хяналтын тайлан, арга хэмжээний баримт материал Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан	2
		3 хүртэл		1
		Арга хэмжээ аваагүй		0
11	Орны фонд ашиглалт	91-100	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт (сүүлийн 3 жилийн байдлаар); Эрүүл мэндийн статистик мэдээ	2
		81-90		1
		80-аас доош		0
12	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь /Сүүлийн 12 сараар/	80-аас дээш%	Тухайн байгууллагын өнгөрсөн хугацаанд авсан сэтгэл ханамжийн судалгааны дундаж	2
		75-80%		1
		75-аас доош%		0
13	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ	80-аас дээш%	Тухайн байгууллагын өнгөрсөн хугацаанд үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дагуу хийсэн ажлын тайлан	2
		75-80%		1
		75-аас доош%		0
14	Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд зориулсан шаардлага хангасан дэд бүтэцийн хангасан байдал	80-100%	Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд зориулсан дэд бүтцийг бүрдүүлсэн тайлан	2
		60-79%		1
		60%-с доош		0

Тав. Шалгуур үзүүлэлтийг үнэлэх аргачилал

5.1 Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгч байгууллага нь урилгад заасан хугацааны дотор шалгуур үзүүлэлтийн ерөнхий болон тусгай шалгуур үзүүлэлт тус бүрээр дор дурдсан баримт материалыг бүрдүүлж харьяалах эрүүл мэндийн төрийн захиргааны байгууллагын сонгон шалгаруулах комисст битүүмжлэн хүлээлгэн өгнө. Үүнд:

- Сонгон шалгаруулалтад оролцох тухай байгууллагын хүсэлт;
- Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажилагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар;
- Байгууллагын дотоод зохион байгуулалт, байршлын бүдүүвч зураг;
- Батлагдсан орны тоог хуваарилсан байгууллагын даргын шийдвэр;

- 
- Тухайн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, орон тоо баталсан шийдвэр, нийгмийн даатгалын НД7,8 тайлангийн хуулбар;
 - ЭТҮХХ-ын тохиолдлыг илрүүлэх, бүртгэх тухай байгууллагын даргын шийдвэр;
 - Дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэх талаар байгууллагын даргын тушаал, дотоод хяналтаар авсан арга хэмжээний тайлан;
 - Байгууллагыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, хэрэгжилтийн өмнөх оны тайлан;
 - Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэх мэргэшсэн хүний нөөцийн мэргэжлийн диплом, үнэмлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл;
 - Хүний нөөцийн чадавхийг сайжруулах сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан;
 - Зайлшгүй шаардлагатай болон яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт, нөөцийн эзлэх хувь;
 - Зайлшгүй шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт;
 - Тусламж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт сүүлийн 3 жилийн байдлаар (өвчлөл, орны фонд ашиглалт, дундаж ор хоног, нас баралт, бусад)
 - Чанарын болон сувилахуйн тусламж, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан;
 - Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайлан;
 - Үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн, дүнгийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан.

5.2 Комисс нь баримт бичиг боловсруулалтын стандартын шаардлага хангасан баримт материалыг хүлээн авч “Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журам”-ын дагуу үнэлгээг хийж, дүнг нэгтгэнэ.

5.3 Ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг үнэлж хангасан, хангаагүй гэсэн үнэлгээ өгнө.


5.4 Тусгай шалгуур үзүүлэлтүүдийг оноогоор дүгнэх бөгөөд шалгуурт заасантай тэнцүү буюу сайн байвал 2, дунд байвал 1, шалгуурт хүрэхгүй сул дүнтэй байвал 0 оноо өгнө.

5.5 Энэхүү аргачлалын 3.1.2, 3.1.3-т заасан эрүүл мэндийн байгууллагын ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийн 80-аас дээш хувийг хангасан бөгөөд тусгай шалгуур үзүүлэлтийн дүн нь 18 ба түүнээс дээш оноо авсан хувийн өмчит эмнэлэг, сувилалыг сонгон шалгаруулалтад тэнцсэн гэж үзнэ.


5.6 Гэрээгээр мэс заслын болон гэмтлийн тусламж, үйлчилгээг дангаар гүйцэтгэх эрүүл мэндийн байгууллагын ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийн 90-ээс дээш хувь хангасан, тусгай шалгуур үзүүлэлтийн дүн нь 22 ба түүнээс дээш оноо авсан хувийн өмчит эмнэлэгийг сонгон шалгаруулалтад тэнцсэн гэж үзнэ.

5.7 Комисс нь сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэх ба шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг холбогдох байгууллагаас лавлаж гаргуулсан байвал зохино.

5.8 Сонгон шалгаруулалтад оролцож буй эрүүл мэндий байгууллагын ирүүлсэн баримт бичиг эргэлзээтэй, зарим шалгуур үзүүлэлтийг магадлах шаардлагатай тохиолдолд газар дээр нь үзэж баримтжуулж болно.



Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
04 дугаар сарын 07-ний өдрийн
13.1 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Улс, бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг болон гадаадын хөрөнгө
оруулалттай эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах
комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга

Л.Зэндмаа, Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл
мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга;

Нарийн бичгийн дарга

М.Оюунчимэг, Эрүүл мэнд, спортын яамны
Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн
хэлтсийн төрөлжсөн мэргэжлийн тусламж,
үйлчилгээний бодлогын хэрэгжилтийн
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн;

Гишүүд

Б.Батжаргал, Эрүүл мэнд, спортын яамны
Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын
эрүүл мэндийн санхүүжилтийн бодлого
төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;

Г.Оюунцэцэг, Эрүүл мэнд, спортын яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын үндсэн
ба төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн
байгууллагын магадлан итгэмжлэлийн
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн;

Л.Ширнэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
мэргэжилтэн;

А.Хишигбаяр /зөвшилцсөнөөр/, Хүн амын
хөгжил, нийгмийн хамгааллын яамны Бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах
мэргэжилтэн;

Х.Өлзийтогтох /зөвшилцсөнөөр/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газрын дэд дарга;


Б.Сарантуяа /зөвшилцсөнөөр/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Эрүүл мэндийн даатгалын газрын ахлах мэргэжилтэн;

Б.Оюунцэцэг /зөвшилцсөнөөр/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын ахлах байцаагч;

Д.Бямбасүрэн /зөвшилцсөнөөр/, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал;

Ц.Дариймаа /зөвшилцсөнөөр/, Чанарын менежерүүдийн холбооны нарийн бичгийн дарга;

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
04 дугаар сарын 07-ний өдрийн
131 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



Загвар

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо: [Урилга нийтлэгдэх] _____

Үйл ажиллагааны нэр : _____

1. [Захиалагчийн нэр] нь эрх бүхий Сонгон шалгаруулалтад оролцогчдыг [Үйлчилгээний талаарх товч тодорхойлолт] үйлчилгээ үзүүлэх тухай Сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.
2. Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой эрүүл мэндийн байгууллага холбогдох баримт бичгийг бүрдүүлэн [Сонгон шалгаруулалт хүлээн авах эцсийн огноо, цаг] өмнө [Хүлээн авах байгууллагын нэр болон дэлгэрэнгүй хаяг]-д ирүүлнэ.
3. Сонгон шалгаруулалтад оролцоход бүрдүүлэх материалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [байгууллагын нэр болон хаяг] –аас авах боломжтой.